

Институтэд бүртгүүлэх сонголтууд: (1) энэ маягтыг бөглөх эсвэл (2) institute.lds.org хаягаар орж, онлайнаар бүртгүүлэх.

Суралцагчийн мэдээлэл Гаргацтай бичнэ үү.

Нэр (овог, нэр)

Дуудагдах нэр	Ашиглах хэл	Сүмийн гишүүнчлэлийн дугаар (хэрэв байвал)
Төрсөн огноо (он, сар, өдөр)	Хүйс ☐ Эр ☐ Эм	Шашин ☐ ХҮГ ☐ Бусад
Шуудангийн хаяг	Хот	Аймаг, сум
Утас	Бид танд мессеж илгээж болох уу? ☐ Тийм ☐ Үгүй	Мессеж хүлээн авах утас
Э-мэйл хаяг	Холбоо барих арга ☐ Э-мэйл ☐ Мессеж ☐ Холбоо бүү барь	
Одоогийн тойрог эсвэл салбар	Одоогийн гадас эсвэл дүүрэг	Сурч буй сургууль (сурдаг бол)

Институтийн ангийн бүртгэл

Курс болон хэсэг	Багш	Хичээл авах өдөр ба цаг
Курс болон хэсэг	Багш	Хичээл авах өдөр ба цаг
Курс болон хэсэг	Багш	Хичээл авах өдөр ба цаг

Суралцагчийн гарын үсэг Та энэхүү бүртгэлд гарын үсэг зурснаар доорх нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа болно.

Суралцагчийн гарын үсэг	Огноо
-------------------------	-------

Гэрээ

Институтэд хамрагдах нь

Институтэд хамрагдах нь онцгой боломж бөгөөд бид та бүхнийг тавтай морилно уу хэмээн урьж байна. Та институтийн журмуудыг дагахаар хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ерөнхийлөгчийн корпорацийн хэлтэс болох Шашны институт, семинар болон үүний холбогдох хуулийн этгээдүүд (цаашид “бид” гэх) нь эдгээр журмыг мөрдөөгүйгээс болж үүсэн гарах аливаа хохиролд хариуцлага хүлээхгүй болохыг хүлээн зөвшөөрч байна.

Суралцагчийн хувийн мэдээлэл хадгалах журам

Та бидэнд энэхүү маягт болон гишүүнчлэлийнхээ бүртгэл дээрх (хэрэв та Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн бол) хувийн мэдээллийг институтэд бүртгэх, институтэд хамрагдах явцад гарч болох аливаа асуулт эсвэл асуудлуудад хариулах зорилгоор цуглуулан, ашиглах зөвшөөрлийг өгч байгаа юм. Таны хувийн мэдээлэл Америкийн Нэгдсэн Улс дахь Сүмийн удирдах газар руу шилжиж болохыг та ойлгож байгаа бөгөөд ийн шилжүүлэхийг зөвшөөрч байгаа. Таны хувийн мэдээллийг Сүмийн түүхийн байнгын бүртгэлд тодорхой бус хугацаагаар хадгалж болно. Бид таны мэдээллийг хэзээ ч худалдахгүй. Бид хүлээн авсан хувийн мэдээллийг алдаж, буруугаар ашиглан, зөвшөөрөлгүй өөрчлөхөөс сэргийлж, нууцлалыг хамгаалахын тулд техникийн хувьд төдийгүй байгууллагын түвшинд анхааран ажилладаг.

Судалгаа ба санал асуулга: Хэрэв танаас судалгаанд эсвэл санал асуулгад оролцохыг хүсвэл үүнд оролцох эсэх нь таны сайн дурын сонголт бөгөөд энэ үйл явцын аль ч үед оролцохоос татгалзаж болно. Таны судалгаанд оролцохдоо өгсөн хувийн мэдээллийг (э-мэйл эсвэл гар утасны дугаар гэх мэт) зөвхөн ирээдүйд хийх судалгаанд эсвэл

санал асуулгуудад оролцох эсэх талаар танаас асуух зорилгоор ашиглах болно. Та ийм маягаар холбогдохоос татгалзаж болно.

Зураг дүрс ашиглах зөвшөөрөл

Бид зарим үед таныг институттэй холбоотой зураг авалт юм уу бичлэгт оролцуулах тохиолдол гарч болно. Эдгээрийг зайн сургалтын үйл ажиллагаа, багшийн сургалт, төгсөлтийн ном, галын дэргэдэх цугларалт, үзүүлэн самбар, вэбсайт зэрэгт эсвэл олон нийтийн цахим хуудаснуудад гэрэл зураг, видео бичлэг хэлбэрээр ашиглах зэргээр оруулж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Эдгээр зорилгоор та өөрийн институттэй холбоотой аливаа зураг болон дуу, дүрс бичлэгүүдийг гаргах, тараах, үзүүлэх, эдгээрийг ашиглан өөр зүйл бүтээх эсвэл лицензээ бусдад ашиглуулах зэргийг цаг хугацаа, давтамж, хэл, газарзүйн хязгаарлалтгүйгээр болон (одоо мэдэгдэхгүй байгаа болон ирээдүйд мэдэгдэх) арга хэрэгслээр ашиглах эрхийг бидэнд олгон, зөвшөөрч байна. Мөн та өөрийн нэр, дуу хоолой, зураг, хуулбар, үзүүлбэрийг ашиглах эсвэл бичлэг хийхийг; мөн тантай ярилцлага хийх болон үүний бичлэгийг хийх; түүнчлэн аливаа бичлэгийг өөрсдийн үзэмжээр хуулбарлах, олшруулах, өөрчлөх, засварлах, тоймлох гэх мэтээр үйлдэх эрхийг бидэнд олгож байна. Та эдгээр зураг, бичлэгийг дахин эмхэтгэн гаргах, борлуулах, зохиогчийн эрх авах, үзүүлэн хийх, олон нийтэд дамжуулах, цахим хэлбэрээр хадгалах болон өөрсдийн хүслээр ямар нэгэн хязгаарлалтгүйгээр тараах эрхийг бидэнд зөвшөөрч байна. Ингэснээр та дээрх байдлаар ашиглах болон хэвлэн нийтлэх ямар нэг болон бүх хариуцлагаас биднийг чөлөөлж байгаа бөгөөд эдгээрээс ямар нэг төлбөр шаардах аливаа эрхийг үгүйсгэж байгаагаа баталж байна.

Интернэт болон онлайн ашиглалтын журам

Бид таныг институтэд хамрагдах боломжоор хангахын тулд хэд хэдэн цахим эх сурвалжийг ашигладаг. Та эдгээр эх сурвалжийг ашиглах эсэхээ өөрөө шийдэх бөгөөд хэрвээ ашиглавал дараах нөхцөлүүдийг зөвшөөрнө. Үүнд:

Таныг манай барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эсвэл утасгүй интернэт технологийг ашиглан интернэтэд холбогдох үед бид таны вэб хөтчөөс мэдээлэл цуглуулж болно. Эдгээр мэдээлэлд таны IP хаяг, вэб хөтчийн төрөл, үйлдлийн систем, хэлний сонголт, мөн манай сайт руу дамжин оруулсан вэб хуудас, нэвтрэн орох тутамд огноо, цаг ба манай вэб хуудаснууд дээрх таны хайлтуудын мэдээлэл орж болно. Мөн бид онлайнээр мэдээлэл цуглуулахдаа cookies болон clear GIF-уудыг ашигладаг. Та вэб хөтчөө өөрийн зочилсон сайтуудаас эдгээр cookies-ийг хүлээн авахгүйгээр эсвэл хүлээн авахын өмнө танд мэдэгддэг байхаар тохируулж болно. Гэхдээ та вэб хөтчөө cookies болон clear GIF-уудыг хүлээн авахгүй байхаар тохиргоо хийсэн тохиолдолд манай сайтын зарим хэсгийг ашиглах юм уу зарим үйлдлийг хийх боломжгүй байх магадлалтай.

Бид институтийн хөтөлбөрүүдийг ("Institute tools") явуулахад ашигладаг вэбсайт, программ хангамж, агуулга, серверийг болон бусад технологи, материалыг эзэмшдэг бөгөөд эзэмших лицензтэй, мөн удирдан ажиллуулдаг болно. Бид Сүмийн ашиг сонирхлыг болон суралцагчдыг хамгаалах зорилгоор институтийн арга хэрэгслийг (Institute Tools) ашиглан явуулж буй бүх харилцааны (э-мэйл, зурвас, олон нийттэй харилцах сайт ба бусад) зүй бус болон хууль бус агуулгад хяналт тавин, шаардлагатай үед шашны удирдагчдад эсвэл хууль сахиулах байгууллагын ажилтнуудад мэдээлж болно. Та ийн хянахыг мөн мэдээллийг дамжуулахыг хүлээн зөвшөөрч байгаа юм. Хэдийгээр бид зарим харилцааг хянаж болох ч бүх харилцааг хянах боломжгүй. Цахим харилцаа бол найдвартай биш. Бид танд хүсээгүй зурвас, материал, вирус болон бусад эвдэн сүйтгэх программ гарч ирэхгүй гэсэн баталгааг гаргахгүй. Зохисгүй агуулгатай зурвасуудыг мэдэгдэлгүй устгаж болох бөгөөд энэ нь тухайн хүлээн авагчид хүрэхгүй байж болно. Та бусдын нэр төрд халдсан, ичгүүр сонжуургүй, хууль бус, мөн үзэн ядсан болон бусдын эрхийг хязгаарласан эсвэл зөрчсөн аливаа зурвасуудыг илгээхгүй байхыг эсвэл давтан илгээхгүй байхыг хүлээн зөвшөөрч байгаа. Институтийн арга

хэрэгслийг зөвхөн бусад суралцагч, багш, шашны удирдагчидтай сайн мэдээний холбогдолтой сэдвүүдээр болон үйл ажиллагааны талаар харилцахад ашиглана. Та институтийн арга хэрэгслээс аливаа эх, зураг, дуу болон видео бичлэгийн файлуудыг татан авч, бусдад тарааж эсвэл сайт дээр байрлуулж (YouTube, Facebook гэх мэт) болохгүй.

Бид институтийн арга хэрэгслийг ашигласнаас юм уу ашиглах чадваргүйгээс мөн бусад хэрэглэгчтэй холбоотойгоор болон хамааралтай вэбсайтуудын эх сурвалж, зурвас зэргээс үүдэн гарах аливаа хохиролд (алга болсон мэдээлэл үүнд багтана) хариуцлага хүлээхгүй. Институтийн арга хэрэгсэл "энэ чигээр нь" ашиглагдахаар өгөгдсөн. Бид аливаа шууд болон шууд бус баталгааг өгдөггүй. Тухайлбал: эзэмшил, борлуулагдах чадвар, аливаа зорилтыг ханган ажиллах баталгааг гаргадаггүй. Бид Институтийн арга хэрэгслийг гацахгүй, алдаа гарахгүй, алдаанууд нь засварлагдана эсвэл институтийн арга хэрэгслүүдийг агуулдаг вэб хуудас эсвэл серверүүд нь вирус болон бусад гэмтэл учруулах зүйлсгүй байна хэмээх баталгааг гаргадаггүй.

Бусад

Та оршин сууж буй орон нутгийнхаа бүх хууль журмыг сахих үүрэгтэй. Харин энэ гэрээ АНУ-ын Юта муж улсын хуулиар зохицуулагддаг бөгөөд хууль зөрчилдөх зарчимд баригдахгүй. Энэхүү гэрээг дагаж мөрдөх талаарх болон институттэй холбоотой аливаа хуулийн заргыг АНУ-ын Юта муж улсын Солт Лэйк гүнлэгийн мужийн болон нэгдсэн улсын шүүхэд шийдвэрлэх бөгөөд та энэ шүүхийн харьяаллаар шийдвэрлэхийг зөвшөөрч байна. Хэрэв энэ гэрээний аль нэг хэсгийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг дагаж мөрдөх эсэх нь хуультай зөрчилдсөн юм уу хүчин төгөлдөр бус байх эсвэл дагаж мөрдөх эрхгүй болох тохиолдолд бусад хэсэг нь хүчинтэй хэвээр үлдэх бөгөөд бид хүчингүй болсон хэсгүүд нь гэрээний чухал хэсгүүд гэж үзсэн тохиолдолд өөрийн хүслээр гэрээг өөрчилж болно.

Хэрвээ танд энэхүү гэрээний талаар ямар нэг асуулт эсвэл санаа зовоосон асуудлууд байгаа бол siregistration@ldschurch.org хаягаар э-мэйл бичих юм уу орон нутгийнхаа институтийн зохицуулагчтай холбоо барина уу.